



МОНГОЛ УЛСЫН  
БАЙГАЛЬ ОРЧИН,  
НОГООН ХӨГЖЛИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2014 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А-181

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Агаарын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2, 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл явуулах журам"-ыг нэгдүгээр, "Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл явуулах заавар"-ыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Тус журмын хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга С.Энхтүвшин, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.


3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан "Журам батлах тухай" Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2011 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн А-131 дугаар тушаалын 3 дугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



С.ОЮУН

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын  
2014 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн  
А-181 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



## **АГААРЫН БОХИРДЛЫН ЭХ ҮҮСВЭРИЙН УЛСЫН НЭГДСЭН ТОО БҮРТГЭЛ ЯВУУЛАХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү журмын зорилго нь агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл явуулах, нэтгэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Агаарын бохирдлын хөдөлгөөнт эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэлийг Авто тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан мэдээлэлд үндэслэнэ.

### **Хоёр. Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл явуулах**

2.1. Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэлийг эх үүсвэрээр нь дараах байдлаар ангилж явуулна:

2.1.1. агаарын бохирдлын суурин эх үүсвэр

2.1.2. агаарын бохирдлын хөдөлгөөнд эх үүсвэр

2.2. Агаарын бохирдлын суурин эх үүсвэрт дараах төрлийн зуухыг хамруулах ба энэ журмын хавсралт 1, 2, 3 дугаар маягтын дагуу улсын тоо бүртгэлийг явуулна:

2.2.1. Ердийн галлагаатай 10 кВт хүртэл хүчин чадалтай зуух. Үүнд: Ахуйн хэрэглээнд ашиглагдаж байгаа уламжлалт болон сайжруулсан зуух, пийщин, усан халаалтын зуух, мөн жижиг үйлдвэрлэл, үйлчилгээ, харуул, хамгаалалтын байранд ашиглагдаж байгаа зуух;

2.2.2. Усан халаалтын 11-100 кВт хүчин чадалтай зуух. Үүнд: Ахуйн хэрэглээнд ашиглагдаж байгаа уурын болон усан халаалтын зуух, технологийн зориулалтай уур үйлдвэрлэдэг зуух, төвлөрсөн болон нэгдсэн дулаан хангамжийн усан халаалтын зуух; барилгын болон томоохон үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглагдаж байгаа зуух;

2.2.3. Дулааны цахилгаан станцын 101 кВт-аас дээш хүчин чадалтай зуух.

2.3. Агаарын бохирдлын хөдөлгөөнт эх үүсвэрт дизель түлш болон шатахуунаар ажилладаг бүх төрлийн автотээврийн хэрэгсэл, өөрөө явагч болон зөөврийн хөдөлгөөнт хэрэгслийг хамруулах ба энэ журмын хавсралт 4 дүгээр маягтын дагуу улсын нэгдсэн тоо бүртгэлийг явуулна.

## **Гурав. Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл явуулахад оролцогч талуудын эрх, үүрэг**

1.1. Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл явуулах ажлыг "Агаарын тухай хууль"<sup>5</sup>-ийн 10.1-т заасан Мэргэжлийн алба нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангаж ажиллана.

1.2. Аймаг, нийслэлийн Засаг дарга агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл явуулах ажлыг харъяалах нутаг дэвсгэртээ жил бүрийн 9 дүгээр сарын 15-аас 11 дүгээр сарын 15-ны хооронд зохион байгуулна.

1.3. Агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэлийг аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг батлагдсан удирдамжийн дагуу явуулна.

1.4. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тухайн аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар, Агаарын чанарын алба, Байгаль орчны алба, Ус цаг уур, орчны шинжилгээний алба, Эрчим хүчний газар, Мэргэжлийн хяналтын газар, Тээвэр, автозамын газрын төлөөллийг оролцуулсан байна.

1.5. Агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэл явуулах Ажлын хэсэг нь дор дурдсан эрх, үүрэгтэй:

1.5.1. агаарын бохирдлын эх үүсвэр эзэмшигч, хариуцагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас тухайн эх үүсвэртэй холбоотой мэдээллийг энэ журмын хавсралт маягтын дагуу авах, түүний үнэн бодит эсэхэд хяналт тавих;

1.5.2. Агаарын бохирдлын эх үүсвэрийн тоо бүртгэлийн мэдээллийг харъяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд энэ журмын хавсралт 5, 6 дугаар маягтын дагуу нэгтгэн боловсруулж, тухай жилийн 12 дугаар сарын 10-ны дотор Засаг даргад тайлагнана.

1.6. Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн агаарын бохирдлын эх үүсвэрийн тоо бүртгэлийн нэгдсэн мэдээллийг өмнөх жилийн мэдээлэлтэй харьцуулан боловсруулж тухайн жилийн 12 дугаар сарын 31-ны дотор Мэргэжлийн албанд хүргүүлнэ.

1.7. Мэргэжлийн алба агаарын бохирдлын эх үүсвэрийн тоо бүртгэлийн мэдээллийг улсын хэмжээнд нэгтгэн боловсруулж дараа оны 1 дүгээр сарын 31-ны дотор байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

1.8. Агаарын бохирдлын эх үүсвэр эзэмшигч, ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага агаарын бохирдлын эх үүсвэрийн талаарх мэдээллийг энэ журмын хавсралт маягтын дагуу үнэн зөв мэдүүлнэ.

1.9. Агаарын бохирдлын томоохон эх үүсвэр эзэмшигч тухай эх үүсвэрийн хаягдал, нөлөөллийг хянах дотоод хяналтын мэдээг гаргана.

---

<sup>5</sup> Агаарын тухай хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2012 оны 22 /739/ дугаарт нийтлэгдсэн.

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын  
2014 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн  
А-181 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



**АГААРЫН БОХИРДЛЫН ЭХ ҮҮСВЭРИЙН УЛСЫН НЭГДСЭН  
ТОО БҮРТГЭЛ ЯВУУЛАХ ЗААВАР**

Д/д	Өгөгдөл	Заавар
1.	<b>Эзэмшигч байгууллага:</b>	Аж ахуйн нэгж байгууллагын нэр, улсын бүртгэлийн дугаар, зуухны зөвшөөрөл, үйл ажиллагааны чиглэл (энд тоосгоны үйлдвэр, төмрийн үйлдвэр гэх мэт), халаадаг объектын нэр (энд сургууль, цэцэрлэг, орон сууц гэх мэт)-ийг бичнэ.
2.	<b>Зуухны байгууламжийн мэдээлэл</b>	Зуух байрлаж буй аймаг, хот, сум дүүрэг, баг хороог тодорхой бичнэ.
3.	<b>Зуухны байгууламжийн байршил</b>	Зуух байршлыг GPS-ээр тодорхойлж бичнэ.
4.	<b>Зуухны байгууламж хариуцагч</b>	Зуухыг хариуцаж буй харилцагчийн овог нэр, албан тушаал, утас, цахим хаягийг тодорхой бичнэ.
5.	<b>Зуух эзэмшигчийн өмчийн хэлбэр</b>	Төрийн, хувийн эзэмшлийн аль нь болохыг /+/ -ээр тэмдэглэнэ.
6.	<b>Зуухны мэдээлэл</b>	Зуухны мэдээллийг зуух тус бүрээр бүртгэнэ. Зуухны марк, үйлдвэрлэсэн улсын нэр, зуухыг суурилуулсан он, сар, өдөр, халах гадаргуугийн талбайг м2-аар илэрхийлнэ. Бүртгэлийг хөтлөхдөө олон төрөлтэй бол өмнөх дугаараар тэмдэглэнэ. Зуухны төрлийг: 1. усан халаалтын зуух 2. уурын зуух 3 халаалтын ба уурын зуухны аль тохирохыг дугаараар тэмдэглэнэ. Жишээ нь: Усан халаалтын зуух бол 1 гэж тэмдэглэнэ. Зуухны нэгж хүчин чадлыг Зуухны агаар өгөх аргыг: 1. Ердийн 2. Үлээх салхилууртай 3. Утаа сорогчтой




		4. Үлээх салхилуур ба утаа сорогчтой зэргийн тохирохыг тоогоор илэрхийлнэ. Зуухны ажиллах хугацааг сараар илэрхийлнэ.
7.	<b>Халуун усны хэрэглээ:</b>	Халаалтын эзэлхүүнийг $m^3$ , халуун усыг $m^3$ , уурыг тн-оор хэмжинэ. Халаалтын хувьд барилгын эзэлхүүн, шалны гадаргууг бичиж болох ба ямар хэмжээг ашигласнаа барилгын эзэлхүүн ( $m^3$ ), шалны талбай( $m^2$ ) гэх мэтээр тодорхойлж бичнэ.
8.	<b>Түлш</b>	Түлшний төрлийг: 1. Нүүрс 2. Хагас кокс 3. Үртсэн шахмал 4. Мод 5. Хий 6. Дизель 7. Бусад // .... өмнөх дугаараар тэмдэглэнэ. Жилд хэрэглэсэн түлшний хэмжээг тн-оор, Нүүрс нийлүүлдэг уурхайг нэрээр нь бичнэ.
9.	<b>Яндан</b>	Яндан тус бүрээр бичнэ. Ашигладаггүй янданг бичихгүй. Яндангийн өргөн, урт, диаметрийг мм-ээр, Малгайтай эсэх: 1. Тийм 2. Үгүй Хяналтын цэгтэй эсэх: 1. Тийм 2. Үгүй
10.	<b>Үнс, нүүрсний талбай</b>	Нүүрс хадгалах талбай: 1. Талбайн хэмжээг $m^2$ -аар, 2. Агуулахтай 3. Бусад Үнс хадгалах талбай: 1. Талбайн хэмжээг $m^2$ -аар 2. Агуулахтай 3. Бусад Үнсний хэмжээг тн/жил-ээр, Үнс зайлуулах арга:

		<ol style="list-style-type: none"> <li>1. Эрх бүхий байгууллагаар ачуулах</li> <li>2. Дахин ашиглах</li> <li>3. Шороогоор булах</li> </ol>
11.	<b>Дотоодын хяналтын багаж:</b>	<p>Ашигладаг багажийн марк, Хэмжилтийн давтамжийг хэмжилт хийдэг байдлаа бичнэ. Тодорхойлох бохирдуулах бодисуудад ямар төрлийн бохирдуулах бодис тодорхойлдогоо бичнэ.</p>
12.	<b>Утаа цэвэрлэх төхөөрөмж:</b>	<p>Утаа цэвэрлэх төхөөрөмжийн нэр, марк, Бохирдуулах бодисын нэр:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. SOx</li> <li>2. NOx</li> <li>3. Тоосонцор</li> </ol> <p>АҮК-ийг бохирдуулах бодис тус бүрд тодорхой бичнэ. Тухайн төхөөрөмж ажилладаг эсэх:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Гийм</li> <li>2. Үгүй</li> </ol>

--oOo--



А-181 Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын  
2014 оны 05 дугаар сарын 09 -ны өдрийн  
дугаар тушаалын 1 дүгээр хэвсрэлтын 2 дугаар маягт




Агаарын бохирдлын суурин эх үүсвэрийн тоо бүртгэл.  
Усан халаалтын 11-100 кВт хүртэл хүчин чадалтай зуух

Нэг. Зуухны байгууламжийн байршил										
Байгууламжийн нэр		аймаг, хот	сум, дүүрэг	баг, хороо	Уртраг			Өргөрөг		
Хоёр. Зуухны байгууламж хариуцагч										
Зуухны байгууламж хариуцагч		Хариуцагчийн овог нэр			Суурин утас		Гар утас		e-Mail address	
Гурван. Зуухны мэдээлэл										
Марк	Үйлдвэрлэсэн улс		Суурилуулсан огноо		Халаах гадаргуу m2	Нэгж хүчин чадал		Ашиглаж буй байдал		
			/ /					O үндсэн O нөөц		
			/ /					O үндсэн O нөөц		
			/ /					O үндсэн O нөөц		
			/ /					O үндсэн O нөөц		
Дөрөв. Халуун усны хэрэглээ			Тав. Түлш			Зургаа. Яндан				
Халаадаг объектын нэр	Объектийн эзлэхүүн m3	Халуун ус m3	Төрөл	Хэрэглээ, тн/жил	Уурхай	Өндөр, м	Дөрвөлжин		Дугуй	Сорьцийн цэг байгаа эсэх
							Урт, м	Өргөн, м	Диаметр, м	
Долоо. Үнс барилч төхөөрөмж				Ням. Үнс, нүүрсний талбай						
Марк	Бохирдуулах бодис	АҮК	Нүүрс хадгалах талбай, m2		Үнс хаях талбай, m2	Үнс, тн/жил	Хаягдлыг хэрхэн зайлуулдаг			



Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын  
2014 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн  
А-181 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 3 дугаар маягт



**Агаарын бохирдлын суурин эх үүсвэрийн тоо бүртгэл.  
Дулааны цахилгаан станцын 101 кВт-аас дээш хүчин чадалтай зуук**

Нэг.Зуухны байгууламжийн байршил														
Байгууламжийн нэр		Аймаг, хот	Сум, дүүрэг	Баг, хороо	Уртраг			Өргөрөг						
Хоёр.Эзэмшигч байгууллага				Гурав.Зуухны байгууламж хариуцагч										
Эзэмшигчийн нэр		Зуухны байгууламж хариуцагч		ААНБ-ын УБ дугаар	Зуухны дугаар		Хариуцагчийн овог нэр		Албан тушаал					
Суурин утас		Гар утас		FAX	e-Mail address		Дөрөв.Өмчийн хэлбэр							
							<input type="radio"/> төрийн		<input type="radio"/> хувийн					
Тав.Зуухны мэдээлэл														
№	Марк	Үйлдвэрлэсэн улс		Суурилуулсан ОГНОО		Халаах гадаргуу, м2		Зуухны төрөл	Нэгж хүчин чадал		Ашиглаж буй байдал			
1											<input type="radio"/> үндсэн	<input type="radio"/> нөөц		
2											<input type="radio"/>	<input type="radio"/>		
3											<input type="radio"/>	<input type="radio"/>		
4											<input type="radio"/>	<input type="radio"/>		
5											<input type="radio"/>	<input type="radio"/>		
6											<input type="radio"/>	<input type="radio"/>		
7											<input type="radio"/>	<input type="radio"/>		
Зургаа. Халуун усны хэрэглээ					Долоо.Түлш			Найм.Яндан						
№	Халаадаг объектын нэр		Объектийн эзлэхүүн м3	Халуун ус м3	Уур тн	Төрөл	Хэрэглээ Тн/жил	Уурхай	№	Дөрвөлжин		Дугуй	Өндөр, м	Сорьцын цэг байгаа
											Урт, м	Өргөн, м	Диаметр, м	
1									1					
2									2					
3									3					
4									4					
Ес.Үнс баригч төхөөрөмж				Арав.Үнс, нүүрсний талбай					Арван нэг. Хяналтын багаж төхөөрөмж					
№	Марк	Бохирдуулагч бодис	АҮК	Нүүрс хадгалах талбай м2	Үнс хаях талбай м2	Үнс тн/жил	Хаягдлыг хэрхэн зайлуулдаг	Марк	Хэмжилтийн давтамж		Хэмжих бодис			





